



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
 ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
 Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,  
 Утас: 25 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
 И-мэйл: contact@afccp.gov.mn, Вэбсайт: www.afccp.gov.mn

2020. 04.20 № 01/637  
 -ны № -Т

ХОВД АЙМГИЙН ОРОН  
 НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР-Т

*Х. Ядамж - г.  
 Хуучин засуу  
 шийдвэрлэх.  
 М. МЗ*

**Тендер шалгаруулалтын тухай**

Танайхаас газраас зарласан Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 9 дүгээр цэцэрлэг/ БСШУСЯ/202001312 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг "Баганат Орд" ХХК-иас тус газарт ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн баримт бичгийн шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбоотой холбогдох тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг болон бусад баримт материалыг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА

Б.ЛХАГВА







Ховд аймаг Жаргалант сум  
Бичигт баг, 7-р судамж 24 тоот  
Утас: 99081236, 99066516  
И-Мэйл: Baganatord83@gmail.com

2020.04.15 № 01/26  
Танай \_\_\_\_\_ -ны \_\_\_\_\_

### ШУДРАГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАРТ

*Хүсэлт гаргах нь:*

Ховд аймгийн худалдан авах ажиллагааны газраас зарласан Цэцэрлэгийн барилга 240 ор /Ховд, Жаргалант сум, 9-р цэцэрлэг/ тендер шалгаруулалтын материал 2020 оны 03 сарын 17 өдөр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-д тавигдсан боловч тендерийн бичиг баримт нь 2020 оны 04-р сарын 07 өдөр, 2020 оны 04-р сарын 09 өдөр удаа дараа хууль бусаар өөрчлөгдсөн байна.

2020 оны 04-р сарын 07 өдөр ТООЗ 5,3(д) заасан түргэн хөрвөх хөрөнгө нь Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт гэсэн заалтын тайлбар хэсэгт, Арилжааны банкны судлагдсан зээлийн авч болох зээлийн хорооны батлагдсан шийдвэр хавсаргах шаардлагатай гэж, 2020 оны 04-р сарын 09 өдөр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээл авах зээлийн хэмжээ 780,000,000 сая төгрөг буюу тендер санал болгож буй төсөв өртгийн 30% байх гэснийг 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөг гэж өөрчилсөн нь хэн нэгэн аж ахуй нэгжид хэт их давуу эрх үүсгэж бусад компани аж ахуй нэгжүүдийн өрсөлдөх чадварыг хязгаарлаж байна гэж үзэж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1, 22.1, 50.1.1-д тус тус заагдсан заалтуудыг зөрчиж байна.

Дээрхи байдлаас үзэхэд аймгийн орон нутгийн өмчийн газар болон холбогдох газруудаас гаргасан үнэлгээний хороо нь өөрийн эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэж дээрхи хуулийн ил тод, нээлттэй шударга өрсөлдөх зарчмыг зөрчиж бусдад давуу эрх олгох гэсэн санаархал, /аливаа нэгэн ажилд банкны тодорхойлолтыг судлан үзэж шийдвэрлэх боломжтой гэдэг дүгнэлтийг үндэслэн үнэлгээний хорооны шийдвэрт харгалзан үздэг болохоос биш шийдвэр нь гараагүй байгаа ажилд ямар зээлийн хорооны дүгнэлт шаардаж байгаа зэрэг/ гаргаж байгаад манай компани болон бусад аж ахуй нэгжүүд илт эсэргүүцэж байна. Уг ажлын үнэлгээний хороонд гомдол гаргасан боловч үнэлгээний хороо нь дахин байгуулагдаагүй харин тендерийн хүлээн авах хугацааг 7-10 хоногоор сунгаж байршуулсан байна. Иймд уг ажлын үнэлгээний хороог шаягаж дахин байгуулж өгнө үү



Т. БАЯНМОНХ